



МОНГОЛБАНК АЖИЛТАН ШАЛГАРУУЛЖ АВНА

Ажлын байр: Эдийн засагч-1

Ажиллах нэгж: Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв (ОНБМТ)

Ажлын байранд тавих шаардлага:

- Боловсрол: Бакалавраас доошгүй зэрэгтэй байх (*Эдийн засгийн сэдвээр судалгааны ажил хийсэн туршилагатай бол давуу тал болно*);
- Дэлхийн эдийн засаг, Монголын эдийн засаг, түүхий эдийн зах зээлийн талаар өргөн хүрээний мэдлэгтэй байх;
- Макро эдийн засаг, мөнгөний бодлогын шилжих механизмын талаарх онолын суурь мэдлэгтэй байх;
- Монголын болон олон улсын судалгааны байгууллагуудаас эрхлэн гаргадаг статистик, тайлан, репортуудыг ашиглах чадвартай байх;
- Санхүү, бүртгэлийн голлох тайлангуудыг унших, анализ хийх чадвартай байх;
- Компьютерийн хэрэглээний програм хангамжуудыг дундаас дээш түвшинд эзэмшсэн байх (*Илтгэл боловсруулах, дизайн бэлддэг програм ашиглах чадвартай бол давуу тал болно*);
- Эдийн засгийн бус мэргэжлийн хүмүүст макро эдийн засгийн талаар тайлбарлан илтгэх чадвар, бичих чадвартай байх;
- Монголын хэвлэл, мэдээллийн зах зээлийн онцлог, олон нийттэй харилцах харилцааны талаар мэдлэгтэй бол давуу тал болно;
- Өндөр түвшний харилцааны чадвар, багаар ажиллах чадвартай байх (*Багийн зохион байгуулалттай аливаа тэмцээн уралдаанд оролцож байсан туршилагатай бол давуу тал болно*);
- Англи хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн байх (*Жич: Англи хэлээр эдийн засгийн судалгааны ажил унших, олон улсын байгууллага болон шинжээч, төлөөлөгчидтэй бичгээр болон амаар чөлөөтэй харилцах чадвартай байх*).

Ерөнхий шаардлага:

- Идэвх санаачилгатай, бүтээлч сэтгэлгээтэй;
- Шуурхай, эрч хүчтэй;
- Хариуцлагатай, ачаалал даах чадвартай;
- Албан бичиг боловсруулах чадвартай;
- Харьцааны соёлтой, хувийн зохион байгуулалт сайтай;
- Тогтвор суурьшилтай ажиллах эрмэлзэлтэй.

Бүрдүүлэх материал:

- Дипломын /нотариатаар баталгаажуулсан/ хуулбар (*Жич: дүнгийн хуулбар хавсаргах*);
- Төрийн албан хаагчийн анкет;
- Товч намтар / CV-Англиар 2 нүүрнээс хэтрэхгүй байх/;
- Ойрын 5 жилийн карьер, Монголбанкинд ажиллахыг хүсч буй шалтгаан, үүнд өөрийн давуу болон сул тал хэрхэн нөлөөлөх зэргийг хамруулан 500 үгэнд багтаан бичиж хавсаргах;
- Монгол Улсын макро эдийн засгийн талаар өөрийн бодлоо 500 үгэнд багтаан бичиж хавсаргах.

Шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн Монголбанкны Төв байрны бичиг хэрэгт авчирч өгнө үү (Ирүүлсэн материалыг буцаахгүй болно). Зөвхөн урьдчилсан шалгаруулалтад тэнцсэн хүмүүстэй холбоо барин бичгийн болон ярилцлагын шалгалтууд авах тул харилцах утас, хаягаа төрийн албан хаагчийн анкетэд тодорхой бичнэ үү.

Материал хүлээн авах сүүлийн хугацаа: 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 17:00 цаг хүртэл.

Монголбанкны ОНБМТ-ийн талаар нэмэлт мэдээлэл:

ОНБМТ нь Монголбанкны үндсэн зорилтын хүрээнд төв банк, мөнгөний бодлоготой холбоотой мэдээллийг олон нийтэд үнэн зөв, ил тод, шуурхай байдлаар хүргэх, олон нийтийн эдийн засгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, улмаар мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахад чиглэн үйл ажиллагаагаа явуулдаг. Ингэхдээ төв банк доторх мэдээллийн урсгал, харилцаа холбоог уялдуулж, төв банкнаас гадагш чиглэсэн мэдээллийн нэгдмэл байдлыг ханган ажилладаг. Тус төв нь Монголбанкны үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2019 он)-ийн хүрээнд төв банкны олон нийттэй харилцах харилцааг шинэ шатанд хүргэх, дэлхийд тэргүүлэх төв банкуудын шилдэг туршлагыг нэвтрүүлэхийг зорьж байна.

ОНБМТ-ийн эдийн засагч нь дараах ажлуудыг хариуцан гүйцэтгэх, эсвэл зохион байгуулах ажилд оролцоно. Үүнд:

- Төв банк, мөнгөний бодлого, макро эдийн засаг, эдийн засгийн суурь ойлголтуудын талаар олон нийтэд (УБ болон орон нутагт) чиглэсэн лекц, сургалт, семинаруудын материал бэлтгэх;
- Бодлого боловсруулагчид, санхүүгийн зах зээлийн оролцогчид, судлаач-эдийн засагчид, эдийн засгийн мэргэшсэн сэтгүүлч нарыг хамарсан эдийн засгийн хэлэлцүүлэг- зохион байгуулах;
- Мөнгөний бодлогын зөвлөлийн хурал, инфляцийн төлөв байдлын тайлан, санхүүгийн тогтвортой байдлын тайлан, хэвлэлийн хурал зэрэг төв банкны олон нийттэй харилцах харилцааны үндсэн бүтээгдэхүүнээр олон нийтэд брифинг хийх ажлыг зохион байгуулах;
- Монголбанкны жилийн тайлан, “Судалгааны товхимол” зэрэг хэвлэмэл бүтээгдэхүүнүүдийг бэлтгэх;
- “Монголбанкны мэдээлэл” сар тутмын товхимолд шаардлагатай материалыг бэлтгэх;
- Монголбанкны удирдлагууд, Хэвлэлийн төлөөлөгчийн олон нийтэд хандаж хэлэх үг, хэвлэлийн мэдэгдэл, хэвлэлд өгөх ярилцлагын төслийг Монголбанкны бусад газар нэгжүүдтэй хамтарч боловсруулах;
- ОНБМТ-ийн ахлах эдийн засагчид шаардлагатай тоон мэдээллүүдийг боловсруулах;
- Медиа зах зээл дээр дүн шинжилгээ хийн, олон нийтэд шаардлагатай байгаа мэдээлэл дээр санал, дүгнэлт боловсруулах;
- Монголбанкны албан ёсны цахим хуудас, сошиал хуудасны мэдээллийг баяжуулахад шаардлагатай материал боловсруулах;
- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн “Монголбанкны эрдэм шинжилгээний хурал”, “Монголбанкны эссений тэмцээн”, “Шилдэг эдийн засгийн нийтлэл” зэрэг уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулах г.м.

Монголбанкны ОНБМТ-ийн чиг үүргийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудаснаас үзнэ үү: <https://www.mongolbank.mn/listdepartment.aspx?id=10>

Нэмэлт мэдээлэл шаардлагатай тохиолдолд 317542 (Захиргаа, хүний нөөцийн хэлтэс) болон 310119 (ОНБМТ) утсаар лавлана уу.

МОНГОЛБАНК